



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 02 дугаар сарын 23

№ 01160 ДЧА №018/96/СТА -ПЧЗ Мандалговь хот

Г

Зөрчил арилгуулах тухай

7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Сайнцагаан сумын Зургаадугаар цэцэрлэгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аudit хийх явцад багш нарт 5 жил тутамд нэг удаа олгодог тэтгэмжийг 60 сар хүрээгүй байхад олгосон зөрчил илрэлээ.

Энэ нь Боловсролын тухай хуулийн 43.1.7-д /Дараах эмгээдэд 5 жил тутамд нэг удаа барын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгох/ заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зорчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагыг тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-д /Хууль, тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтсан гаргуулахгүй байх, үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ Нь:

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Сайнцагаан сумын Зургаадугаар цэцэрлэгийн төсвийн шууд захирагч Д.Энхмаа, нягтлан бодогч Г.Нармандах нарт хариуцуулав.

<p>АЛБАН ШААРДЛАГЫГ</p> <p>ӨГСӨН¹:</p> <p>АУДИТОР <i>[Signature]</i> ТОЮУН-ЭРДЭНЭ</p>	<p>ЗӨВШӨӨРСӨН:</p> <p>ЗАХИРАЛ <i>[Signature]</i> Д.ЭНХМАА</p> <p>НЯГТЛАН БОДОГЧ <i>[Signature]</i> Г.НАРМАНДАХ</p>
--	---

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллаас төвсэн албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрээт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хургуулна.